



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Арвайхээр сумын Түшиг дөлгөөн өрхийн эрүүл мэндийн төвийн 2024
оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит
/хураангуй/

Аудитын код: ӨВА-2025/015/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өвөрхангай аймаг, Арвайхээр сум 2025 он	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: П.Хорлоосүрэн Утас: 70323108 Цахим хаяг: KhorloosurenP@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323108 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоото нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.14 № 96
танай _____-ны № _____-т

ТҮШИГ ДӨЛГӨӨН НӨХӨРЛӨЛИЙН
/ ББН / ДАРГА С.ДОНИДДУЛАМ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түшиг дөлгөөн нөхөрлөл / ББН/-ийн санхүүгийн тайлангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Түшиг дөлгөөн нөхөрлөл / ББН/-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар байгууллагын дотоод хяналтаар илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, мөнгөн хөрөнгийн харилцах данснаас нийт 32,240.9 мянган төгрөгийн гүйлгээг и-баримтгүй шилжүүлсэн, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг тоолж, тооцоо нийлж баталгаажуулаагүй, Худалдан авах ажиллагааны тухай хуулийг зөрчин 106,708.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлыг тендер зохион байгуулалгүйгээр шууд худалдан авсан зэрэг зөрчил илэрч Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийг мөрдөж ажиллаагүй нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзлээ.

Асуудлыг онцолсон хэсэг

“Түшиг дөлгөөн” Өрхийн эрүүл мэндийн төв нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй бөгөөд санхүүгийн тайлан, тодруулгыг сангийн яаманд зориулж Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Санхүүгийн тайлангийн А маяг”-аар буюу СТОУС-д нийцсэн маягтаар тайлагнаж <https://e-balance.mof.gov.mn/> сайтад илгээдэг бол Төрийн аудитын байгууллагад Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 2 дугаар хавсралт “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн”-ийн маягтаар санхүүгийн тайлан,

622502042

тодруулгыг бэлтгэн хүргүүлж, УСНББОУС-д нийцэж байгаа эсэхэд дүгнэлт өгч баталгаажуулж байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР


О.БАТЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	54,759.6	103,187.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	371,109.4	360,744.9
	Нийт хөрөнгийн дүн	425,869.0	463,932.5
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	425,869.0	463,932.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	425,869.0	463,932.5
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	804,425.4	970,424.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	804,645.7	932,360.9
	Үйл ажиллагааны үр дүн	(220.4)	38,063.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(220.4)	38,063.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	426,089.4	425,869.0
	Тайлант оны үр дүн	(220.4)	38,063.5
	Эцсийн үлдэгдэл	425,869.0	463,932.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	713,116.6	889,427.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	643,266.0	817,463.9
	Үйл ажиллагааны ЦМГ	69,850.7	71,963.9
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(72,774.5)	(44,282.1)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(2,923.9)	27,681.8
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(2,923.9)	27,684.2
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	861,746.0
	Урсгал зардал	-	861,746.0
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	889,427.8
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 520,445.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд цаашид эрсдэлээс урьдчилан сэргийлж хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдөж ажиллах 2 зөвлөмж, 3 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт өгөгдөөгүй

3.2 Албан шаардлага

1. Худалдан авах ажиллагааны тухай хуулийг зөрчин 106,708.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлыг тендер зохион байгуулаагүй шууд худалдан авсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 -д "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна:", 31.2-д "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна.", 31.3-д " Энэ хуулийн 32, 33, 34, 35, 36, 37, 38 дугаар зүйл дэх тухайн тендер шалгаруулалтын аргад хамаарах зохицуулалтад тусгайлан өөрөөр заагаагүй асуудлаар энэ хуулийн хоёр, гуравдугаар бүлэгт заасныг баримтална." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжид заасны дагуу ил тод тендер зохион байгуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 16,585.4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 8,222.5 мянган төгрөгийн аж ахуйн материал, 7,433.0 мянган төгрөгийн нормын хувцас (халаад, малгай гэх мэт) нийт 32,240.9 мянган төгрөгийн гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6."Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" заалтуудыг мөрдөөгүй.

Шийдвэрлэсэн нь:

Худалдан авалтын 32,240.9 мянган төгрөгийн и баримтыг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3. Жилийн эцэст 20,751.1 мянган төгрөгийн бараа материал, 360,744.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тоо хэмжээг тооцож, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 2/ тоолсон эд хөрөнгийн үнийг бэлтгэн нийлүүлэгчийн дагалдах баримт, тухайн үеийн зах зээлийн үнийн жишигтэй тулган шалгаж, тооллогын бүртгэлд бичих 3/ агуулахын эмх цэгц, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, анхан шатны бүртгэлийн хөтлөлт, хэмжих хэрэгслийн баталгаажилт, урьдах тооллогоор өгсөн үүргийн биелэлт зэргийг тооллогын явцад шалгаж, дутагдлыг

арилгах арга хэмжээ авах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. СТА-ын "Иж бүрэн байх", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, тооллогын үр дүнг байгууллагын удирдлагын шийдвэрийн дагуу нягтлан бодох бүртгэлд бүртгэн тусгаж цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, хэрэгжүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь

Нөхөрлөлийн бүртгэлийн онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлээ.

2. Байгууллагын дотоод хяналтаар илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1."Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно.", Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 311 дүгээр тогтоол "Нийтлэг журам батлах тухай (ААНБ-ын дотоод хяналт шалгалт)"-ын хавсралт "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь

Байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж, төрийн болон олон нийтийн итгэл суларч, байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүснэ. Иймд дотоод хяналтаар илэрсэн зөрчлүүдийг бүрэн арилгаж, үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаа гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах	Хууль, хяналтын байгууллагад

**Арвайхээр сумын “Түшиг дөлгөөн” өрхийн эрүүл мэндийн төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

									албан шаардлага		шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаа лтны тоо	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, хэрэгжүүлээгүй	1	0	0	0	0	0	1	0				
Байгууллагын дотоод хяналтаар илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй.	1	0					1	0				
Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас нийт 32,240.9 мянган төгрөгийн гүйлгээг И- баримтгүй шилжүүлсэн байна.	1	32,240.9	0	0	1	32,240.9	0	0	0	0	0	0
Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг тоолж, баталгаажуулаагүй.	1	381,496.0	0	0	1	381,496.0	0	0	0	0	0	0
Дүн	4	413,736.9	0	0	2	413,736.9	2	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааны тухай хуулийг зөрчин 52,552.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлыг тендер зохион байгуулалтгүйгээр шууд худалдан авсан байна.	1	106,708.5	0	0	1	106,708.5	0	0
Дүн	0	0			0	0		
Нийт дүн	1	106,708.5	0	0	1	106,708.5	0	0

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР